



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 302

Улаанбаатар хот

“Монсек ҮЦК” ХХК-ийн арилжаанд
оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх захирлын 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 298 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан “Монсек ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2016 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Гишүүнчлэлийн гэрээ”-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг “Монсек ҮЦК” ХХК /М.Отгонбаатар/-д анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР